



ХЭНТИЙ АЙМГИЙН
БАЯН-ОВОО СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 001

Жавхлант

Дотоод хяналт шалгалт хариуцсан
ажлын хэсгийг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай” хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоол /аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам/-ын 1 дүгээр зүйлийн 1.3, 1.5 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Засаг даргын Тамгын газрын Дотоод хяналт шалгалт хариуцсан ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Э.Хонгорзул

Нийгмийн бодлогын мэргэжилтэн

Гишүүдэд: П.Эрдэнэчимэг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Т.Эрдэнэцэцэг

Санхүү албаны дарга

Г.Номинцэцэг

Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга: Н.Мөнхгэрэл

Архив, бичиг хэргийн эрхлэгч

2. Дотоод хяналт шалгалтын журмыг хавсралтаар баталсугай.

3. Дотоод хяналт шалгалтын журмыг мөрдөж, төлөвлөгөө гаргаж, үйл ажиллагааг зохион байгуулж, үр дүнг танилцуулж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч /П.Эрдэнэчимэг/-т үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан 2024 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн А/15 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА

Р.ОЮУНЧИМЭГ